



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 25 өдөр

дугаар 49

Улаанбаатар хот

“БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр
Засгийн газраас авах арга хэмжээний тогтвортой
байдлыг хангах төлөвлөгөө”-г боловсруулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4, 8.1.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авах арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хянах, чиглүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2. БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авах арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан боловсруулж, Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсгийн дарга /Р.Оюунханд/-д үүрэг болгосугай.

3. БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авах арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулах багийг сонгон ажиллуулах, шаардагдах бусад зардлыг Глобаль сангийн ХДХВ/ДОХ-ын төслөөс санхүүжүүлж ажиллахыг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн зохицуулагч /А.Оюунбилэг/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080145

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 сарын 23 өдрийн
49 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

“БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авах арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөө”-г боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хянах, чиглүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн дарга: Р.Оюунханд, Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга
- Орлогч дарга: П.Оюунцэцэг, Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: Б.Батцоож, Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн
- Гишүүд:
- О.Батбаяр, Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн санхүүжилтийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- Д.Байгалмаа, Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- Д.Нарантуяа, Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн байгууллагын төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- И.Оюун-Эрдэнэ, Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
- Я.Буянжаргал, ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Т.Хулан, Нийслэлийн эрүүл мэндийн газрын
хэлтсийн дарга

Ж.Даваалхам, ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын
тандалт судалгааны албаны дарга

О.Түмэндэмбэрэл, Нийгмийн эрүүл
мэндийн хүрээлэнгийн БЗДХ, Сүрьеэ,
гепатит хариуцсан мэргэжилтэн

Ж.Нарантуяа, ДЭМБ-ын мэргэжилтэн
/зөвшилцсөнөөр/

Д.Алтанчимэг, НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн
хөтөлбөрийн зохицуулагч /зөвшилцсөнөөр/

А.Оюунбилэг, Глобаль сангийн дэмжлэгтэй
ДОХ, сүрьеэгийн төслийн зохицуулагч

Б.Мөнхцэцэг, Монголын гэр бүлийн сайн
сайхны нийгэмлэгийн гүйцэтгэх захирал
/зөвшилцсөнөөр/

Д.Мягмардорж, Залуус эрүүл мэнд төрийн бус
байгууллагын гүйцэтгэх захирал
/зөвшилцсөнөөр/

Х.Ням-Өлзий, Төгс бүсгүйчүүд ТББ-ын гүйцэтгэх
захирал /зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 сарын 23 өдрийн
19 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

“БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авах арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөө” боловсруулах ажлын удирдамж

Үндэслэл:

Үндэсний хэмжээнд БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд ДОХ, сүрьеэ хумхаатай тэмцэх Глобаль сан, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд санхүүгийн дэмжлэг үзүүлсээр ирсэн. Тэр дундаа дийлэнх санхүүгийн дэмжлэгийг үзүүлж байгаа байгууллага нь Глобаль сан бөгөөд 2003 оноос хойш ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратегийн хөтөлбөрт тусгагдсан эрсдэлт бүлгийн хүн амыг ХДХВ-ийн халдвараас сэргийлэх, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах, БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх үндэсний хариу арга хэмжээ авах нийгмийн таатай орчинг бүрдүүлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээг, төр, иргэний нийгмийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлсээр ирсэн.

2013 оноос манай орны эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт сайжирч төслийн дэмжлэг авдаг дунд орлоготой улсуудын доод ангилалаас дунд орлоготой улсуудын дээд ангилалд шилжиж байгаатай холбогдуулан олон улсын хандивлагч байгууллагуудын дэмжлэг буурч, Глобаль сангийн ХДХВ, ДОХ-ын төсөл 2017 оны 12 дугаар сард дуусгавар болж байна.

Иймд 2016-2020 онд “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх “БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх дэд хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тогтвортой байдлыг хангах чиглэлээр олон улсын байгууллагын санхүүжилтээс алгуур, үе шаттайгаар Засгийн газрын санхүүжилтэд шилжих асуудлыг тусгасан “Шилжилтийн үе, тогтвортой байдлын төлөвлөгөө” боловсруулах шаардлагатай байна.

ЗОРИЛГО:

2017 – 2020 онд БЗДХ, ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах.

ЗОРИЛТ:

1. “Шилжилтийн үе, тогтвортой байдлын төлөвлөгөө”-г 2016-2020 онд “БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх дэд хөтөлбөр” болон бусад хандивлагч байгууллагуудын бодлого, хөтөлбөртэй уялдуулан боловсруулах,
2. Тогтвортой байдлыг хангах чадавх бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулах

3. "Шилжилтийн үе, тогтвортой байдлын төлөвлөгөө"-г Үндэсний зохицуулах зөвлөл болон бусад хамтрагч талуудад танилцуулах

4. "Шилжилтийн үе, тогтвортой байдлын төлөвлөгөө"-г эрх бүхий байгууллагаар батлуулах

САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА: Глобал сан 50000 доллар хүртэл

ХУГАЦАА: 2016 оны Нэгдүгээр улирал

ХҮРЭХ ҮР ДҮН:

2017-2020 онд хэрэгжих "Шилжилтийн үе, тогтвортой байдлын төлөвлөгөө"-г "БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх дэд хөтөлбөр" болон бусад хандивлагч байгууллагуудын бодлого, хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан байна.

“БЭДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авах арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөө”-г боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөө

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 сарын 23 өдрийн
49 дугаар тушаалын 3 д/гаар
Хавсрелт



№	Үйл ажиллагаа	2 сар		3 сар				
		3-р Долгоо хоног	4-р Долгоо хоног	1-р Долгоо хоног	2-р Долгоо хоног	3-р Долгоо хоног	4-р Долгоо хоног	5-р Долгоо хоног
1	“Шилжилтийн үе, тогтвортой байдлын төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсгийн тушаал баглуулах							
2	“Шилжилтийн үе, тогтвортой байдлын төлөвлөгөө”-г боловсруулах багийн сонгон шалгаруулах							
3	Шилжилтийн үеийн төлөвлөгөөг боловсруулах багийн ажлын явцтай танилцах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хянах, чиглүүлэх уулзалт зохион байгуулах							
4	Төлөвлөгөөг Глобаль сангийн Үндэсний зохицуулах зөвлөл, Эрүүл мэнд, спортын яамны удирдлагын зөвлөлд танилцуулах							
5	Шилжилтийн үеийн төлөвлөгөөг Глобаль санд өргөн барих							